



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/11

Жаргалант

“Цагаан сар-Цагаан идээ-2026” үзэсгэлэн  
худалдааг зохион байгуулах ажлын  
хэсэг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Цагаан сар-цагаан идээ-2026” үзэсгэлэн худалдаанд бүтээгдэхүүний чанар, сав баглаа боодол, эко амт чанарын үзүүлэлтийг хангасан шилдэг үйлдвэрлэгчдийг шалгаруулж шагнаж урамшуулсугай.

2.“Цагаан сар-Цагаан идээ-2026” үзэсгэлэн худалдаанд идэвх санаачилгатай оролцож үндэсний үйлдвэрлэлийг дэмжин, чанар стандарт хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж, шилдэгээр шалгарсан иргэн, хоршоо, нөхөрлөлийн шагналыг хавсралтаар баталсугай.

3.Шагналын 500000 (таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө ДАВААЖАРГАЛ

232601037

Сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын  
02 ны өдрийн А/М дугаар захирамжийн хавсралт



ШАГНАЛ УРАМШУУЛАЛЫН ЖАГСААЛТ

д/д	Овог нэр	Шилдэг бүтээгдэхүүний төрөл	Олгосон шагнал
1	Буяндэлгэр Мандал эрдэнэ хоршоо	Сүү, сүүн бүтээгдэхүүн	100000
2	Ц.Мөнх-Эрдэнэ	Модон эдлэл	100000
3	Энгэр булаг нөхөрлөл Ч.Өлзий	Гар урлал	100000
4	Х.Солонго	Үндэсний хувцас үйлдвэрлэл	100000
5	Н.Лхамсүрэн	Ногоо, даршилсан бүтээгдэхүүн	100000
	Нийт дүн		500000